



ДАРХАН-УУЛ АЙМАГ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 23-06-22/13

Дархан-Уул аймаг

ДАРХАН ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА
ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР ОНӨААТҮГ-Т
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙСЭН ТУХАЙ

Нэг. Нийтлэг зүйл

1.1 Хяналт шалгалтын зорилго

Дархан-Уул аймгийн Засаг даргын баталсан Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөө, 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр баталсан 23-06-22/10 тоот удирдамжийн дагуу Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-ын 2020, 2021 он, 2022 оны эхний 08 сарын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд холбогдох хууль эрх зүйн акт, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, мэргэжлийн заавар зөвлөмж өгөх зорилгоор хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

1.2. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Шалгалтыг Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч Л.Дагийсүрэн 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн ажлын 15 хоногт багтаан хийлээ.

1.3. Шалгалтад хамрагдсан асуудлууд

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм журам, зааврын хэрэгжилт

- Тухайн байгууллагын төсвийн төлөвлөлт, хөрөнгийн зарцуулалт
- Өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалт
- Санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгийн байдал
- Төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, зарцуулалт

4522070028

- Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан
- Байгууллагын нягтлан бодогчийн хууль тогтоомжид заасан үүрэг, төсөвт төвлөрүүлэх орлогын биелэлт
- Байгууллагын эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгийн үзүүлэлтийн байдал, түүнд нөлөөлсөн хүчин зүйлс
- Харилцах данс, мөнгөн кассын үйл ажиллагааны орлого, зарлагын гүйлгээний нотлох баримт, эрх зүйн үндэслэл
- Хөрөнгийн тооллого, тооцоо бодолт, дотоодын хяналтын зохион байгуулалт
- Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд бүрэн тусгаж тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байдал
- Өмнөх шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

Шалгалтад Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-ын Худалдаа хөгжил банк 403151409, Төрийн банк 140800412159, Хас банк 5004979119 тоот дансны болон бэлэн мөнгөний гүйлгээ хамрагдлаа.

1.4. Шалгалтад хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл

Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ нь Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 07 дугаар сарын 27-ний өдрийн 69 дүгээр тогтоолоор байгуулагдан барилга байгууламж барих, засварлах, шинэчлэх, өргөтгөх, ажлыг гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлж эхлүүлэх, гүйцэтгэх явцад батлагдсан зураг, төсөл, стандарт, техникийн нөхцөл болон технологийн хяналт тавих, хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийг үр ашигтай зарцуулах, материал, тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг оновчтой зохион байгуулах, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулан барилга байгууламжийг цаг хугацаанд нь ашиглалтад оруулах чиг үүргийг гүйцэтгэдэг байна.

Аймгийн Засаг даргын 2016 оны А/301 дүгээр захирамжаар бүтэц орон тоог 15 баталсан байсныг 2021 оны 01-А/24 дүгээр захирамжаар Дарга 1, Ерөнхий инженер 1, Барилгын инженер 1, Авто зам ба геодезийн инженер 1, сантехникийн инженер 1, гэрээт инженер 4, барилгын төсөв, норм хариуцсан мэргэжилтэн 1, нягтлан бодогч 1, бичиг хэрэг-нярав 1, үйлчлэгч 1, жолооч 1 гэсэн 14 орон тоотойгоор шинэчлэн баталсан байна.

Санхүүгийн баримтыг баталгаажуулсан албан тушаалтан

Шалгалтад хамрагдсан хугацаанд Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-ын санхүүгийн баримтад гарын үсгийн нэгдүгээрийг

2020 оны 07 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл дарга Н.Батсайхан, 2020 оны 07 дугаар сарын 31-нээс 2020 оны 11 дүгээр сарын 30 өдөр хүртэл даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Батбулган, 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс дарга Д.Батбаяр нар, гарын үсгийн хоёрдугаарыг нягтлан бодогч С.Нарангарав зурж хөрөнгийг захиран зарцуулсан байна.

1.5 Өмнөх шалгалтын талаар

1.5.1 Тус газрын 2020 оны санхүүгийн тайланд тайланд ЦЭСБ-Аудит ХХК аудит хийж “материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан гэж “Зөрчилгүй санал дүгнэлт” өгчээ.

Тус аудитаар худалдан авалтаар НӨАТ-ЫГ 781.8 мянган төгрөгөөр бууруулж татварын өглөгийг дутуу тайлагнасан, тайлант онд 236.4 мянган төгрөгийн шатахууныг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн тул 2 зөвлөмж өгсөн байна.

Мөн үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз 13,221.1 мянган төгрөгийг бусад шиг, алдагдлаар тайлагнаагүй, шатахууны урамшуулал 573.1 мянган төгрөгийг орлого, зардлаар тайлагнасан, ногдол ашгийн өглөгийг 60.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байдалд залруулга хийлгэжээ.

1.5.2. 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд ЦЭСБ-Аудит ХХК санхүүгийн тайлангийн аудит хийж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт нийцүүлэн бүх зүйл материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан гэж “Зөрчилгүй санал дүгнэлт” өгсөн байна.

Аудитаар мөнгөн гүйлгээний тайлангийн эцсийн үлдэгдлийг 132,862.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулж, НӨАТ-ын өглөг 10,988.3 мянга, ААНОАТ-ын өглөг 8,639.2 мянга, нийт 19,627.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

Зөвлөмжийн биелэлтийг бүрэн ханган ажилласан байна.

1.5.3. Дархан-Уул аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2019 онд хийсэн шалгалтаар 2016 оны ногдол ашгийг 25 хувиар тооцож 2903.4 мянга, илүү олгосон ээлжийн амралтын олговор 136.5 мянга, илүү олгосон цалин 327.1 мянга, илүү зарцуулсан шатахууны үнэ 539.6 мянга, нийт 3,906.6 мянган төгрөгийг төсвийн орлогод төвлөрүүлэхээр 4 акт тогтоосон ба үүнийг бүрэн барагдуулсан байна.

1.6 Шалгалтын явцад хийгдсэн ажил

1.6.1 Дархан-Уул аймгийн Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-ын 2020, 2021 он, 2022 оны эхний 8 сарын үйл ажиллагааны орлого, төсвийн санхүүжилт, хуваарилалт, үр дүн, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг мөнгөн хөрөнгө, санхүүгийн анхан шатны баримт материалтай тулган шалгалаа.

1.6.2 Шалгалтын явцад шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий тус газрын дарга, нягтлан бодогч нартай уулзаж асуулга, тодруулга авч ажиллалаа.

1.6.3 Шалгалтын явцад хууль, эрх зүйн бусад актын зөрчигдсөн зүйл, заалтыг холбогдох албан тушаалтнуудад тайлбарлан таниулж, хуулийн хэрэгжилтийг хэрхэн ханган ажиллах талаар мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллалаа.

1.6.4 Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа болон захиргааны шийдвэрийг мэдэгдэх хуудас, түүний үр дүнгийн талаарх тэмдэглэл, захиргааны шийдвэрийн хяналтын дагалдах хуудас, захиргааны шийдвэрийг мэдэгдсэн тэмдэглэл зэргийг хөтлөн захиргааны актын хувийн хэргийн материалыг бүрдүүлэн архивд хүлээлгэн өгөхөд бэлэн болголоо.

Хоёр. Санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалт

2.1 Санхүү, эдийн засгийн үзүүлэлт

2.1.1 Орлогын төлөвлөгөөний биелэлт

Үзүүлэлт	2020 он		2021 он		2022 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Хяналтын зардлын орлого	260,000.0	288,126.1	370,000.0	372,050.6	630,000.0	241,226.7
Дансны кредит хүүний орлого		565.0				
Бусад орлого				1,614.4		
Дүн	260,000.0	288,691.1	370,000.0	373,665.0	630,000.0	241,226.7

Тус газар нь захиалагчийн техникийн хяналтын ажлын зардлын орлогыг:

- 2020 онд 260.0 сая төгрөг олохоор төлөвлөж, тайлангийн эцэст 288.7 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллан төлөвлөгөөг 111.3 % буюу 28.7 сая төгрөгөөр давсан

- 2021 онд 370.0 сая төгрөг байхаар төлөвлөж, тайлангийн эцэст 373.7 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллан төлөвлөгөөг 100.9% буюу 3.7 сая төгрөгөөр давсан,

- 2022 онд 630.0 сая төгрөг байхаар төлөвлөсөн ба оны эхний 08 сарын байдлаар 241.2 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна.

Аймаг сумдын ОНХО, ОНХСан, замын сан, олон улсын зээл, төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлж буй төслүүдэд хяналт тавихаас гадна Барилгын хөгжлийн төвтэй гэрээ байгуулан Дархан-Уул аймагт хэрэгжиж буй улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдэд хяналт тавьж байгаа нь орлого, ашгийг нэмэгдүүлжээ. 2022 онд борлуулалтын орлогын төлөвлөгөө өндөр байгаа нь улсын төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдсэнтэй холбоотой байна.

2.1.2 Зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар

/мян.төг/

Үзүүлэлт	2020 он			2021 он			2022 оны 8-р сар		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү +/-	төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү +/-	төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү +/-
Урсгал зардлын дүн	220,608.3	212,502.3	-7,106.0	336,931.2	304,748.8	-32,182.4	618,910.9	255,006.4	-381,189.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	138,941.9	136,872.3	-2,069.6	125,967.8	125,087.9	-879.9	166,855.0	97,082.8	-69,772.2
Үндсэн цалин	138,941.9	136,872.3	-2,069.6	125,967.8	125,087.9	-879.9	121,040.0	76,850.8	-44,189.2
Нэмэгдэл							18,340.0	10,636.8	-7,703.2
Урамшуулал							14,560.0	3,610.0	-10,950.0
Унаа хоолны хөнгөлөлт							12,915.0	5,985.2	-6,929.8
Ажил олгогчоос НДШ	18,062.4	17,468.5	-593.9	15,746.0	15,840.7	-94.7	20,856.9	12,135.4	-8,721.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,800.0	9,728.0	-1,072.0	10,615.2	10,322.8	-292.4	6,000.0	2,027.5	-3,972.5
Байрны түрээс	10,800.0	9,728.0	-1,072.0	10,615.2	10,322.8	-292.4	6,000.0	2,027.5	-3,972.5
Хангамж, бараа материалын зардал	15,512.0	14,761.0	-751.0	19,757.5	17,822.2	-1,935.3	29,180.0	18,145.4	-11,034.6
Бичиг хэрэг	1,500.0	1,500.0	0	1,500.0	1,496.3	-3.7	2,500.0	1,461.7	-1,038.3
Тээвэр (шатахуун)	9,770.0	9,770.0	0	12,810.5	11,672.0	-1,138.5	19,410.0	12,910.0	-6,500.0
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,092.0	880.6	-211.4	1,092.0	483.1	-608.9	840.0	452.8	-387.2
Сэлбэгийн зардал	2,500.0	1,960.4	-539.6	3,725.0	3,525.9	-199.1	5,600.0	2,763.3	-2,836.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд	650.0	650.0	0	630.0	644.9	-14.9	830.0	557.6	-272.4
Эд хогшил худалдан авах зардал	9,600.0	9,600.0	0	2,340.0	2,340	0	28,140.0	27,294.8	-845.2
Компьютер, техник хэрэгсэл	9,600.0	9,600.0	0	2,340.0	2,340.0	0	8,340.0	7,994.8	-345.2
Багаж хэрэгсэл				0			19,800.0	19,300.0	-500.0
Нормативт зардал							1,400.0	1,329.0	-71.0
Нормын хувцас зөөлөн эдлэл							1,400.0	1,329.0	-71.0
Дотоод албан томилолт	2,442.0	243.9	-2,198.1	1,290.0	276.0	-1,014.0	1,890.0	7,880.6	5,990.6
Сургалтын зардал	1,000.0	500.0	-500.0				1,000.0	0	-1000.0
Бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр, хураамж	3,250.0	2,455.6	-794.4	151,491.0	111,047.5	-40,443.5	75,200.0	7,961.8	-67,238.2
Банк санхүүгийн үйлчилгээний хураамж	150.0	97.8	-52.2	150.0	62.1	-87.9	150.0	81.2	-68.8

Автомашин даатгал	600.0	357.8	-242.2	546.0	237.6	-308.4	450.0	271.7	-178.3
Мэдээлэл сурталчилгаа	500.0	500.0	0	500.0	496.1	-3.9	1,000.0	198.0	-802.0
Аудит, зардал	500.0	500.0	0	500.0	500.0	0	600.0	0	-600.0
Бусад зардал/хөрөнгө оруулалтын ажлын нээлт, хаалт/	1,000.0	1,000.0	0	1,000.0	1,000.0	0	3,000.0	0	-3,000.0
Геодизийн хэмжилт, лабораторийн зардал	500.0	0	-500.0	1,000.0	369.2	-630.8	70,000.0	7,410.9	-62,589.1
Бараа үйлчилгээний бусад зардал	500.0	500.0	0	1,500.0	1,267.4	-232.6	1,500.0	170.0	-1,330.0
Ковид цар тахлын үед шаардлагатай нөөц хөрөнгө				1,500.0	1,267.4	-232.6	500.0	170.0	-330.0
Биеийн тамирын уралдаан тэмцээн	500.0	500.0	0				1,000.0	0	-1,000.0
Өрх гэрт олгох шилжүүлэг	500.0	373.0	-127.0	600.0	560.0	-40.0	2,350.0	420.0	-1,930.0
1 удаагийн эрүүл мэндийн оношлогоо							1,350.0	0	-1,350.0
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	500.0	373.0	-127.0	600.0	560.0	-40.0	1,000.0	420.0	-580.0
Автомашин авах							20,000.0	19,850.0	-150.0
Зохиогчийн хяналтын зардал				147,795.0	108,382.5	-39,412.5	262,000.0	62,038.1	-199,961.9
31-р хорооллын зураг төсөл зохиох зардал /2019 оны ашгаас/	30,000.0	29,600.0	-400.0						
НӨАТ	20,000.0	20,000.0	0						
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ	250,000.0	323,938.0	73,938.0	370,000.0	409,255.7	39,255.7	630,000.0	272,668.4	-357,331.6
Техник хяналтын орлого	250,000.0	323,938	73,938.0	370,000.0	409,255.7	39,255.7	630,000.0	272,668.4	-357,331.6
Татварын өмнөх ашиг	29,371.7	37,882.2	8,490.5	33,068.8	87,482.2	54,413.4	11.1		
Ногдол ашиг 25%	7,347.9	8,026.4	678.5	7,623.7	19,951.7	12,328.0	2,539.0		
Ажиллагсад бүгд	14	13	1	14	11	3	15	14	1

2020 онд бүтэц орон тоо дахь 1 гэрээт ажилтныг ажиллуулаагүйгээс цалин, НДШ, Ковид-19 цар тахал гарч улс даяар хөл хорио тогтоосонтой холбоотойгоор бусад зардал хэмнэгдсэн байна.

2021 оны санхүүгийн тайлангаар 336.9 сая төгрөгийн батлагдсан зардлаас 304.7 сая төгрөг зарцуулж батлагдсан төсвийг 32.2 сая төгрөгөөр буюу 9.5 хувиар хэмнэсэн ба Ковид-19 цар тахал үргэлжилсэнтэй холбоотойгоор зохиогчийн хяналтын зардал болон бусад зардлыг хэмнэжээ.

2022 онд:

Тус газар нь 2022 оны эхний 8 сарын сарын байдлаар төлөвлөгдсөн зардлыг 381.2 сая төгрөгөөр хэмнэсэн ба Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах

арга хэмжээний тухай" 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр заалтад заасны дагуу дотоод зохион байгуулалтыг хийж, урсгал зардлыг хэмнэсэн байна.

2.1.3 Авлагын талаар

/мян.төг/				
№	Үзүүлэлт	2020 оны үлдэгдэл	2021 оны үлдэгдэл	2022 оны 8-р сар үлдэгдэл
1	Дансны авлага	4,308.5	2,613.5	2,613.5
	Авлагын дүн	4,308.5	2,613.5	

2021 онд 2.6 сая төгрөгийн авлагатай байсан ба уг авлага 2022 оны эхний 8 сарын байдлаар барагдаагүй байна.

2.1.4 Өр төлбөрийн талаар

/мян.төг/				
№	Үзүүлэлт	2020 оны үлдэгдэл	2021 оны үлдэгдэл	2022 оны 8-р сар үлдэгдэл
1	Дансны өглөг		1,392.4	0
2	Татварын өглөг	12,979.0	27,360.3	26,470.1
3	Ногдол ашгийн өглөг	8,026.4	19,951.7	0
	Өр төлбөрийн дүн	21,005.4	48,704.4	26,470.1

2021 онд богино хугацаат өр төлбөр 27.7 сая төгрөгөөр өссөн ба богино хугацаат өр төлбөрийн өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйл нь байгууллагын орлого багасаж зайлшгүй төлөгдөх өр төлбөрүүд сар бүр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт өр төлбөрийг бууруулахад анхаарч ажилласны дүнд өр төлбөр 2022 оны эхний 8 сарын байдлаар өр төлбөр 22.2 сая төгрөг буюу 45.6 хувиар буурсан байна.

Санхүү, эдийн засгийн үзүүлэлт

/мян.төг/				
	Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 оны 8-р сар
1	Үндсэн хөрөнгө	42,413.2	30,679.0	65,383.3
2	Эргэлтийн хөрөнгө	139,152.7	238,189.7	357,497.7
3	Үндсэн ажилтнуудын тоо	15	14	14

2.1.5 Хөрөнгийн талаар

Үндсэн хөрөнгө 2020 онд 42,413.2 мянган төгрөг байсан бол 2021 онд 11,734.2.0 мянган төгрөгөөр буурч 30,679.0 мянган төгрөг, 2022 онд 34.7 сая төгрөгөөр өсөж 65,383.3 мянган төгрөг болсон байна.

Үндсэн хөрөнгийн өсөлт 2022 онд компьютер, принтер, багаж техник хэрэгсэл, автомашин худалдан авч хөрөнгөд бүртгэгдсэнээр нэмэгдсэн байна.

2.2 Дотоод хяналт шалгалтын талаар:

Аж ахуйн нэгж байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Монгол Улсын Засгийн

газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын хэрэгжилтийг шалгалаа.

Тус байгууллагын даргын тушаалаар 2022 онд дотоод хяналт шалгалтын ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан автомашины шатахуун идэлтэд хяналт тавьж ажилуулсан байна. Мөн албан хаагчдын ажлын гүйцэтгэлд ерөнхий инженер хяналт тавьж ажилдаг ба байгууллагын бусад үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засгийн хувьд дотоод хяналт хийдэггүй байна.

**Гурав. Санхүү, бүртгэлийн ололттой тал, шалгалтаар илэрсэн
зөрчил дутагдал, зөрчигдсөн хууль, тогтоомж, дүрэм,
журам, стандартын хэрэгжилт**

3.1 Ололттой тал

2020 онд аймгийн Засаг даргын болон, Дархан, Шарын гол, Хонгор, Орхон сумдын Засаг даргын захиалагчийн хяналт гүйцэтгүүлэхээр ирүүлсэн гэрээний дагуу 161 төсөл хөтөлбөр, арга хэмжээ, 2019-2020 онд шилжсэн 16 төсөл арга хэмжээ нийт 177 төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны хяналтыг тавьж ажиллажээ.

Тайлант хугацаанд барилга угсралтын ажлын явцад зураг төсөл, норм дүрэм, стандартын шаардлагыг хэрэгжүүлэн батлагдсан хуваарийг мөрдүүлэн тулгамдсан асуудлыг захиалагч, гүйцэтгэгч бусад холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэж техникийн хяналтыг гүйцэтгэн 1216 зөвлөмж даалгавар өгч биелэлтийг хангуулан, материал ажил үйлчилгээнд 674 лабораторийн дүгнэлт гаргуулан 1548 ил далд, үе шатны ажлын актыг баталгаажуулж, барилга угсралтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийг баталгаажуулан 165 төсөл хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэл, баримт бичгийн иж бүрдлийг ханган захиалагчийн техникийн хяналтын нэгдсэн тайланг гарган байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.

Гүйцэтгэлийн санхүүжилтийг баталгаажуулахдаа төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг ханган магадалшгүй ажлын зардал, зохиогчийн хяналтын зардал, хийгдээгүй ажлуудаас 66.7 сая төгрөгийг буцаан төсөвт төвлөрүүлж, хөрөнгө оруулалтын үр ашигтай байдлыг ханган ажиллажээ.

2021 онд 52.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 112 төсөл хөтөлбөр, 2020-2021 онд шилжсэн 12 төсөл хөтөлбөр буюу нийт 124 төсөл арга хэмжээнд

- ✓ үүрэг даалгаврын биелэлтийг 95,6%-иас дээш хангуулж
- ✓ ажлын явцыг 6614 фото зургаар баримтжуулж
- ✓ үе шатны 1086 ажлыг ил далд ажлын актаар баталгаажуулж

✓ гүйцэтгэлийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан, биелэлтийг дүгнэж
✓ барилгын ажлын тоо хэмжээг тулган шалгаж магадлалгүй ажил болон бусад хийгдээгүй ажлын зардлаас 163.6 сая төгрөгийг хэмнэлт гарган санхүүжих гүйцэтгэлийг баталгаажуулжээ. Үүнээс байнгын ашиглалтад оруулсан 98 төсөл хөтөлбөр, 2021-2022 онд үргэлжлэн хэрэгжих 26 төсөл хөтөлбөр байна.

2022 оны 08-р сарын 31-ний өдрийн байдлаар 117.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 121 төсөл арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэн ажилласан ба 64 төсөл арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээлгэн өгчээ. Тайлант хугацаанд барилга угсралтын ажлын явцад гарсан алдааг залруулах, 430 үүрэг даалгавар зөвлөмж өгч, 845 барилгын материалын лабораторийн сорил, шинжилгээ туршилт тохируулга, үе шатны ажлуудыг хэмжилт хийж 1025 ил далд ажлыг актыг баталгаажуулсан ба 32.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 89 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг баталгаажуулах, ажлын явцыг 8355 фото зургаар баримтжуулах, 44 асуудлыг техникийн зөвлөгөөнөөр шийдвэрлэсэн байна.

3.2 Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал, зөрчигдсөн хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилт

Дархан-Уул аймгийн Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-ын санхүүгийн баримтад хийсэн шалгалтаар дараах зөрчил илэрлээ.

3.2.1. Газрын дүрэм

1. Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 07 дугаар сарын 27-ний өдрийн 69 дүгээр тогтоолоор Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-ын дүрмийг баталж, 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 85, 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 116 дугаар тогтоолоор 2 удаа нэмэлт өөрчлөлт оруулж баталжээ.

Дүрмийн гуравдугаар бүлгийн 3.1 "Үйлдвэрийн газрын бүтэц, орон тоо болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг газрын даргын саналыг үндэслэн Орон нутгийн өмчийн газрын дарга хянаж, аймгийн Засаг дарга тогтооно", тавдугаар бүлгийн 5.8 "Барилгын техник хяналтын зардлаас захиалагчид хяналтын үйл ажиллагаатай холбоотой зардалд тодорхой хэмжээний санхүүжилт олгож болно" гэж тус тус заасан байна.

Шалгалтад хамрагдсан хугацаанд жил бүр сарын 300.0-350.0 мянган төгрөгийн шатахууны зардлыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого хэлтэст олгохоор, аймгийн Засаг даргын 2021 оны 01-А/24 дүгээр захирамжаар тус газрын бүтэц орон тоог 14 байхаар баталсан байхад 2022 оны үйл ажиллагааны төсөвт 15 орон тоотойгоор, Засгийн газрын "Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг

хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 388 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн 5.4 “... төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад төрийн байгууллагууд шинээр автомашин худалдан авах зардал, захиргааны албан контор шинээр барих зардлыг тус тус 100 хувь, ... хэмнэх чиглэл баримтлах” гэж заасан байхад автомашин худалдан авах зэргээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Орон нутгийн өмчийн газрын дарга төсвийг хянаж иржээ.

Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-ын даргын 2022 оны 1/35 дугаар албан бичгээр Орон нутгийн өмчит газарт “... засварын зардлын 5.0 сая төгрөгийг 2021 оны ашгаас зарцуулах зөвшөөрөл олгож өгнө үү” гэж хандсан ба Орон нутгийн өмчийн газраас тус газраас “... 2021 оны ашгаас зарцуулахад татгалзах зүйлгүй болно.” гэсэн хариуг өгсөн байна.

Орон нутгийн өмчийн газрын дарга нь Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн дарга буюу төсвийн шууд захирагч төсөв хянаж байгаа нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1. “харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах”, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36. “Төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 4.1.38. “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 6 дугаар зүйлийн 6.6.2. “төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтад “төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж ...”, “Дүрэм”-ийн 1.5 “Үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч, өмчлөгч нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал байх бөгөөд төлөөлөл хэрэгжүүлэгч нь Засаг дарга байна.” гэж заасантай нийцэхгүй байна.

2. Газрын дүрмийн дөрөв дэх бүлгийн 4.1.7 “Байгууллагын дарга нь тухайн жилийн үйл ажиллагааны орлогоос хамаарч, цалингийн сангийн хэмжээнд ажилтнуудын цалингийн санг тогтоох” гэж баталжээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг 4. үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох" гэж заасан байна.

3.Шалгалтад хамрагдсан онуудад газрын дарга Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан загварын дагуу "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г аймгийн Засаг даргаар батлуулж, гүйцэтгэлийг тайлагнаж ажилласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид "захирал" гэх/ томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараах нөхцөлийг тусгана:" гэж заажээ.

Мөн газрын дарга нь инженер техникийн болон үйлчилгээний албан хаагчидтай хугацаагүй хөдөлмөрийн гэрээ байгуулсан байх ба Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан загварын дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан тайланг авч ажлыг дүгнэж ур чадварын болон үр дүнгийн урамшуулал олгож иржээ. Газрын холбогдох албан тушаалтнаас тодруулахад үнэлэхэд амар хялбар байдаг гэсэн тайлбар өгсөн болно.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.5. "Энэ журмын 2.4-т зааснаас бусад төрийн албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олгоно.", Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 2-т "Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд тогтмол сайн гүйцэтгэдэг буюу бусдаас илүү идэвх санаачилга, өндөр үр дүнтэй ажиллаж байгаа түгээмэл мэргэжлийн албан хаагчдад дараах үндсэн шалгуур үзүүлэлтийг харгалзан ур чадварын нэмэгдэл олгоно." 6-д "Энэхүү нийтлэг журмыг үндэслэн байгууллагын захиргаа нь тухайн албан хаагчид эрхэлж буй ажлын үр дүнгээр ур чадварын нэмэгдэл олгох бусад шалгуур үзүүлэлт, нэмэгдлийн хэмжээг тусгасан журмыг боловсруулан баталж, мөрдүүлнэ." гэж заасан байна.

Иймд байгууллагын удирдлага ур чадвар, урамшуулал хэрхэн олгож байх талаар журам боловсруулан, холбогдох арга хэмжээ авах нь зүйтэй байна.

4. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 85 дугаар тогтоолоор дүрмийн 3 дахь хэсгийн 3.6 дахь заалтын "... захиалагчийн хяналт тавихаас гадна ..." гэсний дараа "олон улсын болон зээлийн ..." гэж нэмж өөрчлөлт оруулсан байх уг хяналтын зардал хаана орж тайлагнах нь тодорхойгүй байна.

Дээрхээс дүгнэхэд холбогдох заалтуудад өөрчлөлт оруулан дүрмийг шинэчлэн батлуулах шаардлагатай.

3.2.2 Худалдан авах ажиллагаа

Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-ын дарга нь 20.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авахаар 2022 оны 01 дүгээр сарын өдрийн ... дугаар "Хөрөнгө гаргах тухай" тушаал гаргасан ба нийлүүлэгчийг сонгон шалгаруулаагүй, Инженер геодези ХХК, Эрхэм зам ХХК-тай худалдан авах гэрээ байгуулан шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.4 дэх заалтад "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.", 8.5 "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.", , Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 дэх заалтад "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Засгийн газрын "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар", "Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 2021 оны 388 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн 5.4 " ... төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад төрийн байгууллагууд шинээр автомашин худалдан авах зардал, захиргааны албан контор шинээр барих зардлыг тус тус 100 хувь, ... хэмнэх чиглэл баримтлах" гэснийг тус тус зөрчсөн байна.

Цаашид шалгалтаар илэрсэн дээрх зөрчлийг арилган Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллах нь зүйтэй байна.

3.2.3 Дотоод албан томилолт

Шалгалтад хамрагдсан онуудад албан томилолтоор ажилласан албан хаагчдад унаа хоол давхардуулан олгосон, мөн албан томилолтын хуудасны удирдамжийг газрын даргаар батлуулаагүй, томилолтоор ажилласан гүйцэтгэл

байхгүй байхад томилолтыг олгосон байх тул Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 5.1.5 "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь заалтад "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасан тул цаашид дахин давтахгүй байх талаар байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт анхаарууллаа.

3.2.4 Шатахуун зарцуулалт

Шалгалтад хамрагдсан онуудын шатахуун зарцуулалтыг шаардах хуудас, жолоочийн тооцооны хуудас, шатахуун олгосон жагсаалт, автомашины марк, шатахууны норм зэргийг тулган баталгаажуулах горимоор хяналт шалгалт хийлээ.

2022 онд Шунхлай петролиум ХХК-тай талоноор шууд худалдан авах гэрээ байгуулан шатахууныг албан хаагчдад олгосон ба зарим шаардах хуудас байхгүй, олгосон талоны үнийн дүнд тохируулан явсан километрийг бичих, буруу бодолт хийх, ижилхэн 2 автомашины бензиний нормыг өөрөөр бодох, даргын тушаалгүйгээр машины нормыг нэмэгдүүлэн илүү бодсон зэрэг зөрчлүүд илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 5.1.5 "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтад "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6 дахь заалтад "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", ЗТХСайдын 2019 оны 390 дүгээр тогтоолын "Автомашины 100 км тутамд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм", ДХББЗГазрын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 "Санхүүгийн анхан шатны бүртгэлийг хөтлүүлэн, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистик мэдээ тайланг гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах" гэснийг тус тус зөрчсөн байна.

Цаашид шалгалтаар илэрсэн дээрх зөрчлийг арилган илүү олгосон шатахууны үнэ 636.1 мянган төгрөгийг төлүүлж төсвийн орлогод төвлөрүүлэхээр Улсын ахлах байцаагчийн акт тогтоолоо.

3.2.5 Ажиллагсдын цалин хөлс

Ажиллагсдын цалин хөлсийг нярвын гаргасан цагийн бүртгэл, нягтлан бодогчийн цалин бодон хэвлэж баталгаажуулсан цалингийн цэс зэргийг тулган баталгаажуулах горимоор хяналт шалгалт хийсэн.

Тус байгууллагын ажиллагсдад олгосон цалин хөлсний тооцоог шалгахад дараах зөрчлүүд илэрлээ.

3.2.5.1 Албан тушаалын тодорхойлолт

Аймгийн Засаг даргын 2021 оны 01-А/24 дүгээр захирамжаар тус газрын бүтэц орон тоонд барилгын төсөв, норм хариуцсан мэргэжилтэн байхаар баталсан ба албан тушаалын тодорхойлолтыг төсөвчин албан тушаалаар газрын дарга баталжээ. Уг төсөвчний албан тушаалын чиг үүргийг аймгийн Засаг даргын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн холбогдох албан тушаалтай давхцаж буй эсэхийг цаашид анхаарах шаардлагатай.

3.2.5.2 Сул зогсолт

Тус газар нь үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан жил бүр хугацаагүй хөдөлмөрийн гэрээтэй 3 инженер техникийн албан хаагчдадаа тухайн оны 1 дүгээр сараас эхлэн 04 дүгээр сарын 01 өдрийг хүртэлх хугацаанд байгууллагын даргын тушаалаар сул зогсолт олгож иржээ.

Энэ талаар газрын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, албан хаагчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд ч тусгагдаагүй байна.

2022 оноос эхлэн мөрдөгдөж буй Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 116 дугаар зүйлийн 116.4 "Улирлын шинжтэй ажил үүргийг гүйцэтгэдэг, хугацаагүй хөдөлмөрийн гэрээ бүхий ажилтны ажиллаагүй хугацааны нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож ажил олгогч төлнө." гэж заасан байх ба 2022 онд олгосон 2,595.2 мянган төгрөгийг тухайн ондоо залруулга хийн суутгах болон дээрх бичиг баримтуудад тодорхой тусган хэрэгжүүлэх талаар байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт анхааруулан, мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллалаа.

3.2.5.3 Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт чөлөөлөлт

Тус байгууллагад хугацаагүй хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг ерөнхий инженер Ч.Батбулган, сантехникийн инженер н.Сүх-Очир нар нь Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрээр хөдөлмөрийн чадвар алдалт 50-60 хувиар тогтоогдсон байхад уг 2 албан хаагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос 2022 онд 1,075.1 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутган авч төсвийн орлогод төвлөрүүлсэн байх ба хуулийн дагуу хөнгөлөлт эдлүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3.санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Хувь хүний орлогын албан татварын тухай

хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтад "хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогын албан татвараас чөлөөлнө", Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1.4 дэх заалтад "Хууль тогтоомжид заасан бусад тохиолдлыг хязгаарлах", ДХББЗГазрын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 Санхүүгийн анхан шатны бүртгэлийг хөтлүүлэн, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистик мэдээ тайланг гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татвар 1,075.1 мянган төгрөгийг хавсралт дахь албан хаагчдад нөхөн олгуулахаар Улсын ахлах байцаагчийн акт тогтоолоо.

3.2.5.4 Үр дүнгийн урамшуулал

Автозамын хяналтын инженер Д.Аюурзанад албан үүргээ гүйцэтгэх явцдаа харилцагч байгууллагын нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулсан тул сахилгын шийтгэлийг газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 25-ний өдрийн Б/25 дугаар тушаалаар ногдуулсан байна. Гэтэл автозамын хяналтын инженер Д.Аюурзаны сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй байхад түүний ажлыг дүгнэн газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн Б/25 дугаар тушаалаар үндсэн цалингийн 40 хувь буюу 374.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгожээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2 дугаар зүйлийн 2.7 "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй." гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд үндэслэлгүй олгосон үр дүнгийн урамшуулал 374.0 мянган төгрөгийг төлүүлж төсвийн орлогод төвлөрүүлэхээр Улсын ахлах байцаагчийн акт тогтоолоо.

3.2.5.5 Бүтэц орон тоонд байхгүй албан тушаал

Тус газрын бүтэц орон тоог аймгийн Засаг даргын 2021 оны 01-А/24 дүгээр захирамжаар Дарга 1, Ерөнхий инженер 1, Барилгын инженер 1, Авто зам ба геодезийн инженер 1, сантехникийн инженер 1, гэрээт инженер 4, барилгын төсөв, норм хариуцсан мэргэжилтэн 1, нягтлан бодогч 1, бичиг хэрэг-нярав 1, үйлчлэгч 1, жолооч 1 гэсэн 14 орон тоотойгоор шинэчлэн баталжээ.

Гэтэл газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн Б/30 дугаар тушаалаар хэвлэл мэдээллийн гэрээт ажилтнаар Жүдэв овогтой Золзаяаг томилж, сарын цалинг 500.0 мянган төгрөгөөр тогтоосон байх ба 5 дугаар сард 450.0 мянган төгрөг олгож, 2022 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн Б/32 дугаар тушаалаар албан тушаалаас нь чөлөөлжээ. Мөн газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн Б/36 дугаар тушаалаар "Байгууллагын цахим хуудас хөгжүүлэх, барилга угсралтын явцын мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх үүрэгт ажлыг автозамын хяналтын инженер Дэлгэрмаа овогтой Аюурзанад хавсран гүйцэтгүүлж, үндсэн цалингийн 5 хувиар тогтоон 7,8 дугаар саруудад 100.0 олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.3 дах заалтад "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", ДХББЗГазрын дүрмийн 3 дугаар бүлгийн 3.1 "Үйлдвэрийн газрын бүтэц орон тоо болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг газрын даргын саналыг үндэслэн Орон нутгийн өмчийн газрын дарга хянаж, аймгийн Засаг дарга тогтооно.", аймгийн Засаг даргын баталсан "Бүтэц орон тоо шинэчлэн батлах тухай" 2021 оны 01-А/24 дүгээр захирамжийг тус тус зөрчсөн байна.

Иймд бүтэц орон тоонд батлагдаагүй ажилтан ажиллуулсан болон хавсран ажилласны нэмэгдэл олгосон 550.0 мянган төгрөгийг төлүүлж төсвийн орлогод төвлөрүүлэхээр Улсын ахлах байцаагчийн акт тогтоолоо.

3.2.6. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн дагуу Шилэн дансны цахим мэдээлэлд 2020, 2021 онд байршуулбал зохих 151 мэдээллийг, 2022 оны 3-р улирлын байдлаар 106 мэдээллийг хугацаанд нь байршуулж хуулийн хэрэгжилтийг 100.0%-тай хангасан байна.

Шилэн дансны цахим системд үнэн зөв оруулсан эсэх талаар түүвэрлэн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын шийдвэрийн хуулбарыг оруулаагүй байх ба цаашид зөрчлийг арилган Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахыг холбогдох ажилтнуудад анхааруулан, мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллалаа.

Дөрөв. Авсан арга хэмжээ, дүгнэлт, санал

4.1 Авсан арга хэмжээ

4.1.1 Шалгалтаар илэрсэн дээрх зөрчилт үйлдлүүд нь орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-ын дарга, нягтлан бодогч нарт танилцуулж мэргэжлийн зөвлөгөө, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

4.1.2 Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулж 1,075.1 мянган төгрөгийг албан хаагчдад олгохоор, 1,560.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэхээр шийдвэрлэн Улсын ахлах байцаагчийн акт тогтоосон болно.

4.2 Дүгнэлт

4.2.1 Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэл нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хөтлөгдсөн, анхан шатны баримтын бүрдэл хангалттай байна.

4.2.2 Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй шинээр батлагдсан хууль дүрмийг сайтар судалж байгууллагын дүрмийг шинэчлэх шаардлагатай байна.

4.2.3 Санхүүгийн тайлан, цалингийн 2 өөр программ ашиглаж байгааг нэгтгэсэн шинэ программ авч ажиллах шаардлагатай.

4.3 Санал

4.3.1 Дархан-Уул аймгийн Засаг даргад:

1. Тус газрын дүрмийг эрх бүхий байгууллагаас батлан гаргасан хууль, дүрэм, журмын хүрээнд шинэчлэн батлуулах.

2. Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын албан хаагчдын цалин хөлсний нийтлэг жишгийг батлуулж, мөрдөж ажиллах.

4.3.2 Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-т:

1. Шалгалтаар илэрснийг зөрчлийг арилгаж эрх бүхий байгууллагаас батлан гаргасан хууль, дүрэм, журам, норм нормативын хэрэгжилтийг бүрэн ханган ажиллах.

2. Худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөн ажиллах.

3. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах.

ТЭМДЭГЛЭЛ

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
Л.ДАГИЙСҮРЭН



ТАНИЛЦСАН:

ДАРХАН ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА

НЯГТЛАН БОДОГЧ

Д.БАТБАЯР

С.НАРАНГАРАВ

